



МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ. ТУУВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД

Службатэй зорилтад хэрхэн оржсан цэвэр № 11  
жас 1976-д № 367308 Факс (976) 11-312315  
E-mail: info@mtm.mn http://www.mtm.gov.mn

2020.08.03 № 0113543  
танаа 2020.07.24-ны № 02

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
ГДАМДИННЯМ ТАНАА

Эрхэм гишүүн танд авто замын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, хэрэгжилтийг үр дүнтэй хангахад анхаарч санаа тавьж байгаад талархлаа илэрхийлье.

Танаас ирүүлсэн Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажилтай холбогдох асуулгад хариу, тайлбарыг хавсралтаар бэлтгэн хүргүүллээ.



681795

Зам тээврийн хөдлүүлийн сайдын  
2020 оны 06 дугаар сарын 03  
өдрийн 09:35 Малбан-бичгийн  
хэрслээр

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Г.ДАМДИННЯМЫН**

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД Л.ХАЛТАРТ**

**2020 ОНЫ 07 ДУГААР САРЫН 21-НИЙ ӨДӨР**

**ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ**

**1. Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажлын явцын талаар:**

Азийн хөгжлийн банк /АХБ/-ны МОН-3679/3786 зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй "Бус нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын тесөл"-ийн Улаанбаатар-Дархан чиглэлийн одоо байгаа 204.11 км авто замын өргөтгөл шинэчлэлтийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах 5 багц хэсэг бүхий олон улсын тендерийг АХБ-ны "Худалдан авах ажиллагааны журам"-ын дагуу 2019 оны 3-5 дугаар саруудад зохион байгуулж, сонгон шалгаруулалтын үр дүнд дараах гэрээг байгуулсан. Үүнд:

Багцын дугаар	Авто замын чиглэл, урт	Гүйцэтгэгч байгууллага	Гэрээний үнийн дүн /ам.доллар/	Гэрээ байгуулсан огноо
Багц 1-1	Баруун аймаг салах тойрог уулзвараас Хар мотод давааны ар хүртэлх 37.26 км авто зам	БНХАУ-ын Хэйлонжиан Жиньеи Рөүд энд Бридж	13 064 749.90	2019.06.12
Багц 1-2	Хар модот давааны араас Урьхан хүртэлх 45.5 км авто зам	БНХАУ-ын Чайна Стэйт Шинжиан Констракшн Инженеринг групп	13 777 743.90	2019.06.14
Багц 1-3	Урьханаас Сүмбэрийн уулзвар хүртэлх 45.74 км авто зам	БНХАУ-ын Гүйкоу Хайвэй Инженеринг Групп	14 491 347.09	2019.06.14
Багц 1-4	Сүмбэрийн уулзвараас Цайдамын хөндий хүртэлх 45.08 км авто зам	БНХАУ-ын Чайна Стэйт Шинжиан Констракшн Инженеринг групп	11 710 750.58	2019.06.14
Багц 1-5	Цайдамын хөндийгээс Дарханы тойрог уулзвар хүртэлх 30.53 км авто зам	БНХАУ-ын Чайна Же-Инженеринг Корпораци	9 834 336.56	2019.06.12
Нийт дүн			62 878 928.03	

Зам барилгын ажлын гэрээнд "ажил дуусах" хугацааг "ажил эхэлсэн" өдрөөс хойш 365 хоног буюу 1 жилийн дараа байхаар заасан.

Зам барилгын ажил 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдөр эхэлсэн ба ажлыг 2020 оны 06 дугаар сард дуусахаар төлөвлөгдсөн байсан.

2019 онд нийт зам барилгын ажлын 70 орчим хувийг гүйцэтгэж, хучилтын ажлыг дуусгахаар төлөвлөсөн боловч нийт ажлын 25.1 хувийг гүйцэтгэсэн. (Багц 1 хэсэг 45.74%, Багц 2 хэсэг 9.49%, Багц 3 хэсэг 39.27%, Багц 4 хэсэг 5.30%, Багц 5 хэсэг 24.60%-ын ажлыг тус тус гүйцэтгэсэн.)

Зам барилгын ажлыг 2019 оны 06 сарын 27-ны өдрөөс 11 сарын 01-ний өдрийг хүртэл хэрэгжүүлсэн ба ажлын талбайд 5 үндсэн гүйцэтгэгч, дотоодын 24 туслан гүйцэтгэгчийн 1144 хүн (үүнээс гадаад-238, дотоод-906 хүн), нийт 627 машин, техник, тоног төхөөрөмж ажилласан.

Зам барилгын ажлын график, төлөвлөгөөний хоцрогдолд цаг агаарын хүндрэлтэй нөхцөл болон бусад хүчин зүйлүүд нөлөөлсөн хэдий ч зарим гүйцэтгэгч байгууллагын удирдлага зохион байгуулалтын хангартгүй байдал нөлөөлсөн.

Зам барилгын ажлын хэрэгжилт хангартгүй Багц 2 болон Багц 4 хэсгийн гүйцэтгэгч компанийд удаа дараа ажлыг эрчимжүүлэхтэй холбогдох зөвлөмж чиглэл, үүрэг даалгавар ёгч ажилласан боловч үр дүн гараагүй. Тус компанийтай хариуцлага тооцох, гэрээг цуцлах санал, хүсэлтийг холбогдох журмын дагуу төслийг санхүүжүүлэгч АХБ-нд удаа дараа тавьсан. АХБ-аас зам барилгын ажлын гэрээг цуцлахад гарч болзошгүй эрсдэл /гэрээ цуцлах тохиолдолд дахин тендер зарлаж хугацаа алдах, гэрээний үнэ өсөх, гүйцэтгэгч байгууллагаас гомдол гарах тохиолдолд олон улсын арбитороор шийдвэрлэгдэх ба хэрэг шийдвэрлэгдэх хүртэл тендер зарлах боломжгүй болох гэх мэт/ байгааг зөвлөж анхаарулсан болно.

Өвлийн улиралд түр замаар хөдөлгөөн нэвтрүүлэх боломжгүй /даваа, гувээтэй хэсэгт халтиргаа, гулгаа үүсэх тул/ болсон тул хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хүрээнд 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс төслийн үндсэн авто замын трассаар хөдөлгөөн нээж ажилласан.

2020 оны зам барилгын бэлтгэл ажлыг 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлүүлж, үндсэн ажлыг 03 дугаар сарын 20-ны өдөр эхлүүлэхээр, өнгөрсөн оны зам барилгын ажлын график, төлөвлөгөөний хоцрогдлыг нөхөж, барилгын ажлыг 2020 оны 06 сард багтаан дуусгах зорилтын хүрээнд энэ зам барилгын ажлын талбайд нийт 1298 гадаад, 325 дотоод ажиллах хүч, 658 машин, тоног төхөөрөмжийг ажиллуулахаар тус тус төлөвлөсөн.

Гэвч дэлхий нийтэд тархаад буй коронавирусын тархалт, дэгдэлтийн улмаас Монгол Улс, БНХАУ хоорондын авто зам, төмөр зам болон агаарын замаар нэвтрэх зорчигч тээврийн хөдөлгөөнийг 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс 04 дүгээр сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд зогсоо шийдвэр гарсан ба тус хугацаа удаа дараа сунгагдсан. Энэ нөхцөл байдал нь зам барилгын ажлыг төлөвлөсөн хугацаанд нь эхлүүлэх, шуурхай зохион байгуулахад хүндрэл учруулсан.

2020 оны зам барилгын ажлыг төлөвлөсөн хугацаанд эхлүүлэх хүрээнд нэн тэргүүн эзлжид шаардлагатай байсан инженер, техникийн нийт 105 гадаад ажиллах хүчийг тусгай горимоор оруулж, ажлыг эхлүүлэх хүсэлтийг Засгийн газар, Улсын онцгой комисст тавьж холбогдох шийдвэрийг гаргуулж 03 дугаар сард Монгол Улсад ирүүлэх бэлтгэл хангасан боловч, олон нийтийн эсэргүүцлээс шалтгаалан гадаад ажиллах хүчийг ирүүлэх асуудал хойшлогдсон.

Ийнхүү үүссэн нөхцөл байдлаас шалтгаалан зам барилгын ажил гэрээт хугацаанд нь дуусгах боломжгүй болсон ба 2020 онд ч багтааж дуусгаж чадахгүй байх эрсдэл үүссэн. (Цар тахлын улмаас бэлтгэл болон үндсэн зам барилгын ажлыг 3 сарын хугацааг буюу 2, 3, 4 дүгээр саруудыг алдсан.)

Зам, тээврийн хөгжлийн яамнаас цаг алдалгүй зам барилгын ажлыг эхлүүлэх шаардлагыг гүйцэтгэгч байгууллагуудад тавьж ажилласан. Үүний дунд Багц 1, Багц 3, Багц 5 хэсгийн барилгын ажлын бэлтгэл ажил болон түр замын засварын ажлыг 03 дугаар сарын 15-ны өдрөөс дотоодын туслан гүйцэтгэгч болон үндсэн гүйцэтгэгчийн Монгол ажилчдын хүчээр үе шаттайгаар эхлүүлсэн.

Багц 1, 3, 5 дугаар багц хэсгүүдэд түр замын ажлын засварын ажлыг 03 сарын 15-ны өдөр эхлүүлж үндсэн зам барилгын ажлыг 04 дүгээр сарын 06-ны өдөр эхэлсэн.

Дээрх багц хэсгүүдэд 2020 оны зам барилгын ажил эхэлсэнээс хойш 2020 оны 08 дугаар сарын 01-ийг хүртэлх зам барилгын ажлын гүйцэтгэлийн хувь дараах байдалтай байна. Үүнд:

№	Багц хэсэг	2019 оны ажлын гүйцэтгэл	2020 онд хийж гүйцэтгэсэн ажил	2020.08.01-ний байдлаарх ажлын гүйцэтгэл
1.	Багц 1-1: Баруун аймаг салах тойрог уулзвараас Хар мотод давааны ар хүртэлх 37.26 км авто зам	45.52%	7.61%	53.13%
2.	Багц 1-3: Урьханаас Сүмбэрийн уулзвар хүртэлх 45.74 км авто зам	39.27%	3.64%	42.91%
3.	Багц 1-5: Цайдамын хөндийгөөс Дарханы тойрог уулзвар хүртэлх 30.53 км авто зам	24.60%	13.59%	38.19%

Зам барилгын ажлын Багц 2 болон Багц 4 хэсгийн 2020 оны зам барилгын ажилд ахиц, үр дүн гаралгүй байна.

Зам барилгын ажлын Багц 2 хэсэгт еренхий гүйцэтгэгч нь "Койн ТТБХ" ХХК-тай газар шорооны ажлын гүйцэтгүүлэхээр туслан гүйцэтгэгчийн гэрээг байгуулсан. Тус компани нь 06 дугаар сарын 16-ны өдрөөс ажлын талбайд гарч газар шорооны ажлыг эхлүүлсэн хэдий ч үндсэн гүйцэтгэгчээс санхүүжилт хийгдэхгүй байгаа шалтгаанаар гүйцэтгэл хангальгүй байна. Багц 4 хэсэгт туслан гүйцэтгэгчийн гэрээ байгуулах компани олдохгүй байгаа шалтгаанаар ажил эхлээгүй байна.

Зам барилгын ажлын багц хэсэг тус бүрт нийтлэг тулгамдаж буй асуудал нь үндсэн гүйцэтгэгч байгууллагын шийдвэр гаргах удирдах ажилтан, санхүүгийн ажилтан, голлох инженер техникийн ажилтан ажлын талбайд байхгүйгээс санхүүжилт, голлох материалын хангамж саатаж, түүнчлэн туслан гүйцэтгэгчээр хийлгэх ажлын шийдвэр маш удаан гарч ажлын хэрэгжилтэд саад учруулж байгаа болно.

Энэ асуудлын шийдвэрлэх хүрээнд гадаад ажиллах хүчийг үе шаттайгаар тусгай горимоор Монгол Улсад нэвтрүүлэх асуудлыг дахин холбогдох байгууллагуудад тавьж, эхний ээлжийн Багц 1, Багц 3, Багц 5 хэсгүүдийн удирдах болон голлох инженер, техникийн нийт 26 гадаад ажилтан 2020 оны 07 дугаар сарын 09-ны өдөр холбогдох журмын дагуу Монгол Улсад оруулж ирэн барилгын ажлын талбайд ажиглан тусгаарлаж, 2020 оны 07 дугаар сарын 29-ний өдөр тусгаарлалтаас гарган ажилд нь оруулаад байна. 2 дугаар ээлжийн нийт 7 гадаад ажиллах хүчийг 07 дугаар сарын 27-ны өдөр Монгол Улсад оруулж ирэн тусгаарлаж байгаа ба 3-р ээлжийн 16 гадаад ажиллах хүчийг 2020 орны 08 дугаар сарын 05-ны өдөр оруулж ирэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Багц 2 болон Багц 4 хэсгийн гүйцэтгэгч болох "Чайна Стэйт Шинжиан Констракшн Инженеринг групп" –ын байрлах нутаг дэвсгэр болох БНХАУ-ын Шинжиан мужид КОВИД-19-ийн дахин дэгдэлтийн улмаас онцгой байдал зарлаж, хөл хороо тогтоосон байгаа тул гадаад ажиллах хүчийг Монгол Улсад оруулж ирэхэд хүндрэл гарч байгаа талаар гүйцэтгэгчээс мэдэгдээд байна.

Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажлын 5 багц хэсгийн барилгын ажлын гэрээнд тус бүр заасан "ажил дуусах хугацаа"-г КОВИД-19 өвчний нөхцөл байдал, гүйцэтгэгч байгууллагаас ирүүлсэн хүсэлт, АХБ-ны зөвлөмж, зөвшөөрлийг үндэслэн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаагаар сунгахаар шийдвэрлэсэн. Ажил дуусах хугацааг сунгахтай холбогдуулан Багц 1, Багц 3, Багц 5 хэсгийн гэрээнд нэмэлт өөрчлөлт хийсэн. Багц 2 болон Багц 4 хэсгийн

гэрээний нэмэлт өөрчлөлтийн төслийг албажуулж ирүүлэх асуудал гүйцэтгэгч талаас хүлээгдэж байна.

Зам барилгын ажлын хэрэгжилтийн явцад үүсээд байгаа нөхцөл байдал болоод цаг агаарын нөхцөл байдалд үндэслэн 2020 онд Багц 1 хэсгийн 37.26 км, Багц 3 хэсгийн 45.74 км, Багц 5 хэсгийн 30.53 км нийт 113.53 км авто замын хучилтын ажлыг 10 дугаар сард багтаан дуусгаж, 11 дүгээр сард холбогдох тэмдэг, тэмдэглэгээ, заслын ажлыг гүйцэтгэж, 12 дугаар сард хөдөлгөөн нээхээр төлөвлөн холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. Цаг агаарын хүндрэлтэй нөхцөл байдал үүсэх тохиолдолд төлөвлөсөн хугацаанд үе шатны ажлыг дуусгахад хүндрэл гарах эрсдэл байна. Үе шатны ажил тус бүрээр хийж дуусгах хугацааг хавсралтад узүүлэв.

Багц 2 хэсгийн 45.5 км болон Багц 4 хэсгийн 45.08 км нийт 90.58 км авто замыг ажлыг 2020 онд хэрэгжүүлж дуусах боломжгүй болсон. Тус хэсгийн үндсэн болон түр замаар хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангахад чиглэгдсэн арга хэмжээг авахаар АХБ, гүйцэтгэгч болон зөвлөх компаниудтай зөвшилцэж байна. Эдгээр багц хэсгүүдийн нийт 70.48 км-т хуучин хучилтаар хөдөлгөөн явагдаж байгаа ба тус хэсгүүдэд гарсан нүх болон бусад эвдрэлүүдийг засварлах, хучилт хуулагдсан байгаа нийт 20.1 км хэсэгт хөнгөвчилсөн суурь, хучилт барих арга хэмжээ авахаар холбогдох тооцоо, судалгааг хийж байна.

**2. Гүйцэтгэгч байгууллагуудын техник, санхүү, хүн хүчиний нөөц тус замыг барьж чадах эсэх, танай яамны зүгээс хяналт шалгалтын ажлыг хэрхэн хийж, ямар дүгнэлт хийж байгаа талаар:**

Зам барилгын ажлын үндсэн гүйцэтгэгч байгууллагуудын гадаад ажиллах хүч КОВИД -19 –ийн нөхцөл байдлаас шалтгаалан Монгол Улсад бүрэн орж ирж чадаагүйгээс Багц 1, Багц 3, Багц 5 хэсгүүдэд дотоодын туслан гүйцэтгэгч болон үндсэн гүйцэтгэгчийн дотоод ажилчдын хүчээр ажил хэрэгжиж байна.

Дээр Багц хэсгүүдийн ажлын талбайд 2020 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар туслан болон үндсэн гүйцэтгэгчийн 8 аж ахуйн нэгжийн дараах хүн хүч /дотоодын/, машин механизм, тоног төхөөрөмж ажиллаж байна. Үүнд:

	Багц 1-1	Багц 1-3	Багц 1-5	Нийт
Хүн хүч	184	135	58	377
Машин механизмын тоног төхөөрөмж	61	79	36	176

Эдгээр ажиллах хүч, тоног төхөөрөмж нь 2020 оны 10 дугаар сард багтаан авто замын хучилтын ажлыг дуусгахад хүрэлцэхгүй ба гүйцэтгэгч нарт хүчин чадлаа нэмэгдүүлэх, үйлвэрлэлийн баазын сууринуулалт, тохируулгын ажлын эрчимжүүлэх шаардлага тавьж байна. Гүйцэтгэгч нар холбогдох арга хэмжээг авч байна.

Түүнчлэн дотоодын туслан гүйцэтгэгчид болон үндсэн гүйцэтгэгчийн дотоодын ажилчид үндсэн гүйцэтгэгчээс санхүүгийн шууд хараат байгаа нь цаг хугацаа алдах, ажил зогсох нөхцөл бий болж байсан.

Энэ хүрээнд гүйцэтгэгч байгууллагуудын шийдвэр гаргах, эрх мэдэл бүхий гадаад ажилчдиг Монгол Улсад тусгай горимоор оруулж ирэх асуудлыг үе шаттайгаар хэрэгжүүлж байгаа ба дээрх тулгамдсан асуудлыг зохицуулах боломж бүрдэж байна.

Зам барилгын ажилд төхник, төхнолийн хяналтын зөвлөх үйлчилгээг БНЭУ-ын "Intercontinental Consultants & Technocrats Pvt Ltd" компани болон түүний туслан гүйцэтгэгч

"Ай Си Ти Сайн консалтинг" ХХК үзүүлж байна. Зөвлөх нь өдөр тутмын чанарын хяналтыг тавьж байгаа шаардлагатай зөвлөмж чиглэлээр гүйцэтгэгчийн ханган ажиллаж байна.

Зам барилгын ажил хэрэгжиж эхэлснээс хойш Зам, тээврийн хөгжлийн яам нь Цагдаагийн ерөнхий газрын Тээврийн цагдаагийн албатай гэрээ байгуулан гэрээт цагдаагийн тасаг авто замын дагууд ажиллуулж хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

Тээврийн цагдаагийн албаны албан ёсны мэдээллээр зам барилгын ажил хэрэгжих хугацаанд буюу 2019 оны 06 сарын 17-аас 2019 оны 12 сарын 31-ний өдөр, 2020 оны 01 сарын 01-ны өдрөөс 2020 оны 06 сарын 30-ны өдрийн хүртэлх хугацаанд Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замд бүртгэгдсэн осол, хэргийн тоо нь өмнөх оны тайлант хугацаан дахь тоо баримттай харьцуулахад буурсан үзүүлэлттэй байгаа болно. /Албан ёсны мэдээллийг хавсралтад үзүүлэв./

Мөн зам барилгын ажлын хэрэгжилтийн явц байдалд Төсөл хэрэгжүүлэх нэгж болон яамны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар хяналт тавьж, газар дээр нь үзлэг шалгалт хийж, шаардлагатай дэмжлэгээр ханган ажиллаж байна.

### **3. Тухайн замыг яаралтай ашиглалтад оруулахад тулгарч буй асуудал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар:**

Зам барилгын ажлын аль болох богино хугацаанд ашиглалтад оруулахад дараах тулгамдсан асуудал гарч байна.

- Зам барилгын ажилд ашиглагдах голлох материал болох цементийн хомсдол нь гүүр, хоолойн ажил, цементээр бэхжүүлсэн суурийн ажлыг тасралтгүй хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэж байна. Цемент үйлдвэрлэгч байгууллагуудад бүтээн байгуулалтын ажилд дэмжлэг үзүүлэх хүрээнд тасралтгүй нийлүүлэх хүсэлтийг хүргүүлсэн хэдий ч нийлүүлэлт зарим багц хэсэгт тасалдсан хэвээр байна.
- Зам барилгын үйлдвэрлэл, завод, тоног төхөөрөмжийг ажиллуулах голлох оператор, ажилтнуудыг Монгол улсад оруулж ирэх асуудал, мөн тусгай горимоор 21 хоног тусгаарлах нь зам барилгын ажил хугацаа алдахад хүргэж байна.
- Зам барилгын ажлын Багц 2 болон Багц 4 хэсгийн гүйцэтгэгчээс тодорхой арга хэмжээ авахгүй, ажил эхлээгүй байгаагаас тус багц хэсгийн ажил 2020 онд дуусахгүй нөхцөл байдал бий болгосны зэрэгцээ өвлийн улиралд авто замын ашиглалтад хүндрэлтэй нөхцөл байдал үүсгэхээр болж байна. АХБ-аас Багц 2 болон Багц 4 хэсгийн гэрээг захиалагчийн зүгээс цуцлах нь эрсдэлтэй тул гүйцэтгэгчийн талаас гэрээг цуцлах хүсэлт гаргах хүртэл хүлээцтэй хандахыг зөвлөмж болгосон. Багц 2 болон Багц 4 хэсэг нэгэнт энэ онд дуусах боломжгүй болж байгаа тул одоо байгаа замын ашиглалтын нөхцөл байдлыг сайжруулахад чиглэгдсэн засварын ажлыг гүйцэтгэх холбогдох тооцоо, судалгааг хийж байна.
- Цаг агаарын нөхцөл байдал, үргэлжилсэн их устай бороо нь зам барилгын ажилд саад болж байна. Тухайлбал 5 сард 3 удаагийн үргэлжилсэн устай борооноос шалтгаалж 10 хоног, 6 сард мөн 3 удаагийн устай борооноос шалтгаалж 6 хоног, 7 сард 4 удаагийн үргэлжилсэн устай борооноос шалтгаалж 13 хоног тус замын барилгын технологи үйл ажиллагаа saatсан. Түүнчлэн 10 дугаар сард эрт хүйтэрх тохиолдолд хучилтын ажлыг технологийн горимын дагуу гүйцэтгэхэд хүндрэл гарахаар байна. Цаг агаарын хүндрэлтэй нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх хүрээнд багц хэсгүүдийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, зэлжийн зохион байгуулалтаар ажлыг гүйцэтгүүлэх арга хэмжээг авч байна.

УЛААНБААТАР-ДАРХАН ЧИГЛЭЛИЙН 204.11 КМ АВТО ЗАМЫН ӨРҮГТӨЛ, ШИНЭЧЛЭЛТИЙН БАГЦ 1, БАГЦ 3, БАГЦ 5 - Р ХЭЗСГИЙН БАРИЛГЫН ҮЕ ШАТНЫ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Ажлын нэр	Х/Н	Нийт тоо хэмжээ	2019 онтын ажлын гүйцэтгэл	2020.08.01-ний өдрийн бий болгарх ажлын гүйцэтгэлтэй сессион дүнгээр	Үзүүлэлт ажил	8 сар				9 сар				10 сар				11 сар					
							1	2	3	4	1	2	3	4	1	2	3	4	1	2	3	4		
<b>БАГЦ 1. Баруун зийнаг салак тойргүүр Уулзараас Хар мотод даваланы 37.26 км авто зам</b>																								
1	Дугуй хоолойн ажил	ЦЭГ	36	36	-	36	36	12	12	73%	73%	343.681.46	3244.54	306.734.34	2750.66	20.989.82	20.989.82	20.989.82	20.989.82	20.989.82	20.989.82	20.989.82	20.989.82	
2	Дөрвөлжийн хоолойн ажил	ЦЭГ	14	14	-	14	14	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
3	Гүүрийн ажил	ЦЭГ	2	2	-	2	2	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
4	Далангийн дүүргэлт	М3	346.926.00	273.781.46	-	346.926.00	273.781.46	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
5	Ухмылын ажил	М3	309.485.00	290.900.34	-	309.485.00	290.900.34	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
6	Дэд суриний ажил	М3	145.764.60	86.399.78	-	145.764.60	86.399.78	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
7	Цементээр бэхжүүлсан суриний доод үе	М3	74.905.00	23.969.60	-	74.905.00	23.969.60	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
8	Цементээр бэхжүүлсан суриний дээд үе	М3	68.598.90	22.157.23	-	68.598.90	22.157.23	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
9	Асфальтбетон хүчинт	М3	16.922.50	4.079.30	-	16.922.50	4.079.30	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
10	Тэмдэг тэмдэглэгээ	М	89.115.00	-	-	89.115.00	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
11	Заслын ажил	КМ	37.26	-	-	37.26	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
12	Хөдөлгөөн нээх	КМ	37.26	-	-	37.26	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
<b>БАГЦ 3. Үрьзханаас Сумбаарийн уулзарх 45.74 км авто зам</b>																								
1	Дугуй хоолойн ажил	ЦЭГ	50	24	-	50	24	7	7	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
2	Дөрвөлжийн хоолойн ажил	ЦЭГ	17	7	-	17	7	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
3	Далангийн дүүргэлт	М3	444.862.00	381.037.96	-	444.862.00	381.037.96	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
4	Ухмылын ажил	М3	359.124.00	275.535.48	-	359.124.00	275.535.48	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
5	Дэд суриний ажил	М3	179.950.00	147.591.30	-	179.950.00	147.591.30	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
6	Цементээр бэхжүүлсан суриний доод үе	М3	90.563.00	26.770.00	-	90.563.00	26.770.00	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
7	Цементээр бэхжүүлсан суриний дээд үе	М3	85.446.00	7.980.00	-	85.446.00	7.980.00	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
8	Асфальт бетон хүчинт	М3	20.700.00	4.32.00	-	20.700.00	4.32.00	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
9	Тэмдэг тэмдэглэгээ	М	137.220.00	-	-	137.220.00	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
10	Заслын ажил	КМ	37.26	-	-	37.26	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
11	Хөдөлгөөн нээх	КМ	45.74	-	-	45.74	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
<b>БАГЦ 5. Цайдамын хөндийгээс дарханы тойрог уулзарх 30.53 км авто зам</b>																								
1	Дугуй хоолойн ажил	ЦЭГ	15	1	-	15	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
2	Дөрвөлжийн хоолойн ажил	ЦЭГ	19	2	-	19	2	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
3	Далангийн дүүргэлт	М3	367.579.00	334.956.00	-	367.579.00	334.956.00	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
4	Ухмылын ажил	М3	170.508.00	84.428.00	-	170.508.00	84.428.00	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
5	Дэд суриний ажил	М3	125.471.00	43.789.00	-	125.471.00	43.789.00	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
6	Цементээр бэхжүүлсан суриний доод үе	М3	63.504.00	18.750.00	-	63.504.00	18.750.00	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
7	Цементээр бэхжүүлсан суриний дээд үе	М3	60.651.00	-	-	60.651.00	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
8	Асфальт бетон хүчинт	М3	14.526.00	-	-	14.526.00	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
9	Тэмдэг тэмдэглэгээ	М	97.362.00	-	-	97.362.00	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
10	Заслын ажил	КМ	30.53	-	-	30.53	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
11	Хөдөлгөөн нээх	КМ	30.53	-	-	30.53	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Жи: Цаг агаарын хүчэрэлтэй нэхцэн байдал чусж токтолдолд дээрх төвлөгөөний дагуу ч шатны ажлыг гүйцэтгэх хүчдрэл гарах эрдээлтэй болно.



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ТӨВИЙН НАГДААГИЙН АЛБА

14230 Улаанбаатар, Төвийн шүүрэлтийн дэд залуусын  
Олимийн чамчилсаны 10-р хороо, төхөн 16-т, төхөн 7, төхөн 16-т  
Урсул www.traffic.mn.gov.mn  
Email traffic@traffic.mn.gov.mn

2020. 01. 22 № 15-2/60

танай \_\_\_\_\_ ний № \_\_\_\_\_ -1

ЗАМ. ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД  
Б.ЭНХАМГАЛАН ТАНАА

Цагдаагийн ерөнхий газар болон "Авто тээврийн үндэсний төв" ТӨҮГазрын 2019 оны хамтран ажиллах ХАГ19/39-2019/90 гэрээний 2 13-д заасны дагуу "Улаанбаатар - Дархан" хүртэлх замд 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд гарсан зам. тээврийн осол хэргийн судалгааг өмнөх оны мөн үетэй харьцуулан хүргүүлэв.

Хавсралт 1 хуудастай.

ЗАМЫН ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГА  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Д.ДАШДОРЖ


001432475

**"УЛААНБААТАР-ДАРХАН" ХҮРТЭЛХ ЗАМД  
БҮРТГЭГДСЭН ОСОЛ ХЭРГИЙН ТОО  
/2019.06.17-2019.12.31-ны байдлаар/**

2020 01 01

Уланбаатар хот

"Улаанбаатар-Дархан"-ны чиглэлийн бүртгэгдсэн осол	Бүртгэгдсэн осол			Гэмт хэрэг			Нас барсан хүн			Гэмтсэн хүн		
	2018.06.17-12.31	2019.06.17-12.31	харьцуулалт									
	172	138	-19.8	44	39	-11.4	22	14	-36.4	48	50	4.2

Мэдээ гаргасан: Тээврийн цагдаагийн албаны, Захиргааны удирдлагын  
газрын Мэдээлэл судалгааны мэргэжилтэн,  
цагдаагийн дэслэгч   
Б.Базаррагчаа

**"УЛААНБААТАР-ДАРХАН" ХҮРТЭЛХ ЗАМД БҮРТГЭГДСЭН ОСОЛ ХЭРГИЙН ТОО**  
 /2020.01.01-2020 06.30-ны байдлаар/

2020.07.01

Улаанбаатар хот

Бүртгэгдсэн осол	Гэмт хэрэг	Нас барсан хүн	Гэмтсэн хүн	xapb4yyuнаам
2019.01.01-06.30				xapb4yyuнаам
2020.01.01-06.30				xapb4yyuнаам
2020.01.01-06.30				xapb4yyuнаам
2020.01.01-06.30				xapb4yyuнаам
2019.01.01-06.30				xapb4yyuнаам
105	42	-60.0	38	5
				-85.8
				14
				3
				-78.6
				46
				7
				-84.8

Мэдээ гаргасан: Тээврийн цагдаагийн албаны, Захиргааны удирдлагын газрын мэдээлэл  
 судалгааны мэргэжилтэн, цагдаагийн дэслэгч  
 Б.Базаррагчаа